

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

БОТЬ



ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ СУРГАЛТ,
СУДАЛГААНЫ ТӨВ
2022 он

"МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН
СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН
ЭМХЭТГЭЛ" БОТЬ НОМЫН
ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУНД
ХИЙСЭН ХЭРЭГЛЭЭНИЙ
СУДАЛГАА

Боловсруулсан: З. Баянсүрэн
/Социологич, судлаач/
Хянасан: С.Нэргүй /Шүүхийн
захиргааны сургалт, судалгааны
төвийн дарга

Агуулга

| | |
|--|----|
| График, Хүснэгтийн жагсаалт | 2 |
| Хураангуй | 3 |
| 1. судалгааны арга зүй..... | 3 |
| 1.1 Судалгааны зорилго ба хамрах хүрээ | 3 |
| 1.1.1 Арга зүй..... | 3 |
| 1.1.2 Судалгааны түүвэр..... | 4 |
| 1.1.3 Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж..... | 5 |
| 2. Судалгааны үр дүн..... | 7 |
| 3. Дүгнэлт..... | 14 |
| 4. Хавсралт..... | 15 |



ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Графикийн жагсаалт

| | |
|--|----|
| ГРАФИК 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС | 5 |
| ГРАФИК 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ЭРХ ЗҮЙЧ МЭРГЭЖИЛТЭЙ ЭСЭХ БОЛОН ХҮЙСИЙН ХАРЬЦАА..... | 5 |
| ГРАФИК 3. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ | 6 |
| ГРАФИК 4. БОТЬ НОМЫГ ХЭР АШИГЛАДАГ БОЛОХЫГ ЕРӨНХИЙД НЬ ХАРУУЛАВ | 9 |
| ГРАФИК 5. БОТИОС АЛЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРГҮҮД ИЛҮҮ ХЭРЭГ БОЛДОГ ВЭ?..... | 9 |
| ГРАФИК 6. ТАНЫ БОДЛООР ШҮҮХИЙН СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛД ХЭВЛЭГДЭЖ БҮЙ ШИЙДВЭРИЙН ЧАНАРЫГ ҮНЭЛНЭ ҮҮ. | 10 |
| ГРАФИК 7. ШҮҮХИЙН СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ БОТИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭВЛЭХ ШААРДЛАГАТАЙ ЮУ? ГЭСЭН АСУУЛГЫГ СУБЪЕКТ ТУС БҮРЭЭР ХАРЬЦУУЛАН ХАРУУЛАВ | 11 |
| ГРАФИК 8. ШҮҮХИЙН СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ БОТИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭВЛЭХ ШААРДЛАГАТАЙ ЮУ? ГЭСЭН АСУУЛГЫГ СУБЪЕКТ ТУС БҮРИЙГ 100% ГЭЖ ҮЗЭН СУБЪЕКТ ТУС БҮРИЙН ХУВЬД ХАРЬЦУУЛАН ХАРУУЛАВ 12 | |
| ГРАФИК 9. “МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН СОНГОМОЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ” ГЭСЭН ОДООГИЙН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГАТАЙ ЭСЭХИЙГ ХАРУУЛАВ | 13 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|--|----|
| Хүснэгт 1. Түүврийн хэмжээг тогтоох аргачлал | 4 |
| Хүснэгт 2. Монгол Улсын сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номоос аль ботийг ашигладаг вэ? | 7 |
| Хүснэгт 3. Тус ботийг хэр ашигладаг болохыг хариулав..... | 8 |
| Хүснэгт 4. Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл нь дараах зорилтод хүрч чадаж буй эсэхийг үнэлнэ үү. | 10 |
| Хүснэгт 5..... | 13 |

ХУРААНГУЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлийг 2016 оноос эрхлэн гаргаж 2021 оны 3 дугаар сард 6 дахь боть номоо олон нийтийн хүртээл болгосон.

Энэхүү бүтээл нь хуулийн салбарын бидний мэдлэг, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, жишиг тогтооход ач холбогдол бүхий судалгааны чухал хэрэглэгдэхүүн, эрх зүйн үндсэн эх сурвалж болсон.

Цаашид уг номыг үргэлжлүүлэн хэвлэх хэрэгцээ шаардлагыг үнэлэх, тодорхойлох зайлшгүй шаардлагыг үнэлэхийн тулд бид уншигчдын дунд хэрэглэгчдийн судалгаа явуулж, дүн шинжилгээ хийв.

Судалгааг google forms ашиглан тус номын хэрэглэгчид ашиглах боломжтой фейсбүүк групп-д байршуулах болон нийслэл дэх захиргааны хэргийн бүх шатны шүүх аймаг орон нутгийн бүх шатны шүүх болон прокурорын тамгын газарт судалгааны ажилд хамтарч ажиллах тухай албан бичиг хүргүүлэн мэдээлэл цуглуулж, SPSS болон EXCEL дээр боловсруулав.

1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


1.1 Судалгааны зорилго ба хамрах хүрээ

Энэхүү судалгаагаар шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл нь зорилгодоо хүрч буй байдлыг үнэлэх, цаашид үргэлжлүүлэн хэвлэх, хэвлэх тохиолдолд анхаарах асуудлуудыг тодорхойлох зорилготой юм.

1.1.1 Арга зүй

Суурь судалгаа нь үндсэн гурван үе шатнаас бүрдэх ба доорх дүрсэд эдгээр шатуудыг нарийвчлан дүрслэв.

Дүрс 1. Судалгааны үйл явц



Судалгааны бэлтгэл үе шатанд судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулж, мэдээлэл цуглуулалтын шатанд холбогдох facebook page болон group-д байршуулж, мэдээлэл цуглуулалтын ажил эхлэв. Мэдээлэл цуглуулалтын бүхий л явцад чанарын шаардлага хангахуйц мэдээлэл цуглуулахын тулд мэдээллийн чанарын хяналтыг гүйцэтгэж, шаардлага хангаагүй судалгааг хассан. Цаашлаад судалгааны эцсийн

шатанд цугларсан мэдээллийг excel-д оруулан, нэлээлттэй асуулгыг кодолж, spss25 судалгааны програм дээр дата боловсруулалт хийгдэж суурь судалгааны эцсийн тайланг боловсруулсан.

1.1.2 Судалгааны түүвэр

Тоон судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо зорилтот хэрэглэгчдийн түвшинд төлөөлөхүйц байдлаар тодорхойлсон. Түүврийн хэмжээг гаргахдаа судалгааны түүвэр тооцоолдог www.surveymonkey.com-ийг ашиглав. Ингэхдээ ойролцоогоор нийт хэвлэгдсэн 2,810 /ойролцоогоор/ ширхэг ном байгаа гэж үзэн 95 хувийн итгэх түвшинээр 6 хувийн алдаа гарах магадлалаар тооцоолон түүврийн хэмжээг тогтооход 244 хэрэглэгч хамруулах байсан төлөвлөгөөтэй байсан бол судалгаанд оролцогчдийн тоо 205 хүрэхэд эх олонлогийг төлөөлөх чадвартай гэж үзэн мэдээлэл цуглуулалтын ажлыг эцэслэн дараагийн үе шатруу орсон.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээг тогтоох аргачлал

| Хэвлэгдсэн боть | Хэвлэгдсэн хэмжээ/ ширхэг, ойролцоогоор/ |
|-----------------|--|
| 1-р боть | 500 |
| 2-р боть | 500 |
| 3-р боть | 500 |
| 4-р боть | 510 |
| 5-р боть | 500 |
| 6-р боть | 300 |
| Нийт | 2,810 |

Зураг 1. Түүврийн тооцоолол

Calculate your sample size

Population Size ①: 2810

Confidence Level (%) ①: 95

Margin of Error (%) ①: 6

Sample size: **244**


$$\text{Sample size} = \frac{\frac{z^2 \times p(1-p)}{e^2}}{1 + \left(\frac{z^2 \times p(1-p)}{e^2 N}\right)}$$

Энэхүү судалгааг Google forms буюу компьютерт суурилсан зайнаас мэдээлэл цуглуулах аргыг ашигласан ба дунджаар нэг судалгаа 7 минут үргэлжилэхээр 2022 оны 4-р сарын 28-аас 5-р сарын 19 хүртэл нийт 21 хоногийн хугацаанд мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгуулж, нийт 205 оролцогчийг хамруулсан.

1.1.3 Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж

Насны хувьд 33-37 нас, 38-аас дээш насныхан нийт судалгаанд оролцогчдын 67 хувийг эзэлсэн байна.


График 1. Судалгаанд оролцогчдын нас



Судалгаанд хамрагдсан оролцогчдын боловсролын түвшинг харвал 50 хувь нь бакалавр, 43% нь магистр, 4 хувь нь бүрэн дунд байсан бол үлдсэн 3 хувь нь докторын зэрэгтэй бөгөөд 54 хувь нь эрх зүйч мэргэжилтэй байна.

Харин хүйсийн хувьд 65 хувь нь эмэгтэй, 35 хувь нь эрэгтэй байна.

График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, эрх зүйч мэргэжилтэй эсэх болон хүйсийн харьцаа



Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн хувьд бусад хуульч 25.9 хувийг (n=53), шүүгч 24.9 хувийг (n=51) эзэлсэн нь хамгийн өндөр хувьтай байна.

График 3. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт



2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцсон 205 хэрэглэгчдийн хувьд Монгол Улсын сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номыг давхардсан тоогоор нийт 439 номыг ашигласан байна.

Боть тус бүрийг 100 хувь гэж үзвэл үүнээс 1-р ботийг 21 хувь, 2-оос 4 дүгээр ботийг тус бүр 15 хувь ашигласан байна.

Боть номын хэрэглэгчдийг ажил эрхлэлтээр нь харахад 1-ээс 5-р ботийг шүүгч нар илүү их ашигласан бол 6-р ботийг бусад шүүгч нар илүү их ашигласан байна.

Хүснэгт 2. Монгол Улсын сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номоос аль ботийг ашигладаг вэ?

| Ажил эрхлэлт/боть | | 1-р боть | 2-р боть | 3-р боть | 4-р боть | 5-р боть | 6-р боть | Ашиглаж байгаагүй | Нийт |
|--------------------------------|------|----------|----------|----------|----------|----------|----------|-------------------|------|
| Архивч | Тоо | - | - | - | - | - | - | 5 | 5 |
| | Хувь | - | - | - | - | - | - | 9.4 | |
| Багш, судлаач | Тоо | 9 | 5 | 5 | 6 | 5 | 5 | 4 | 39 |
| | Хувь | 10 | 7.4 | 7.6 | 9.1 | 9.4 | 11.6 | 7.5 | |
| Оюутан | Тоо | 15 | 9 | 7 | 3 | 2 | - | - | 36 |
| | Хувь | 16.7 | 13.2 | 10.6 | 4.5 | 3.8 | - | - | |
| Өмгөөлөгч | Тоо | 7 | 3 | 3 | 4 | 2 | 1 | 3 | 23 |
| | Хувь | 7.8 | 4.4 | 4.5 | 6.1 | 3.8 | 2.3 | 5.7 | |
| Прокурор | Тоо | 3 | 2 | 3 | 3 | 1 | 2 | - | 14 |
| | Хувь | 3.3 | 2.9 | 4.5 | 4.5 | 1.9 | 4.7 | - | |
| Шүүгч | Тоо | 25 | 27 | 30 | 29 | 28 | 24 | 6 | 169 |
| | Хувь | 27.8 | 39.7 | 45.5 | 43.9 | 52.8 | 55.8 | 11.3 | |
| Шүүгчийн туслах | Тоо | 5 | 2 | - | 2 | 1 | 1 | 3 | 14 |
| | Хувь | 5.6 | 2.9 | - | 3 | 1.9 | 2.3 | 5.7 | |
| Шүүхийн захиргааны ажилтан | Тоо | 1 | 2 | 3 | 2 | 2 | 2 | 3 | 15 |
| | Хувь | 1.1 | 2.9 | 4.5 | 3 | 3.8 | 4.7 | 5.7 | |
| ШХНБ-ын дарга | Тоо | - | 1 | 1 | 1 | - | - | 7 | 10 |
| | Хувь | - | 1.5 | 1.5 | 1.5 | - | - | 13.2 | |
| Бусад хуульч | Тоо | 23 | 15 | 14 | 14 | 12 | 7 | 19 | 104 |
| | Хувь | 25.6 | 22.1 | 21.2 | 21.2 | 22.6 | 16.3 | 35.8 | |
| Шүүхийн тамгын газрын дарга | Тоо | 1 | 1 | - | 1 | - | 1 | - | 4 |
| | Хувь | 1.1 | 1.5 | - | 1.5 | - | 2.3 | - | |
| Төрийн албан хаагч болон бусад | Тоо | 1 | 1 | - | 1 | - | - | 3 | 6 |
| | Хувь | 1.1 | 1.5 | - | 1.5 | - | - | 5.7 | |
| Нийт /Ашигласан боть/ | | 90 | 68 | 66 | 66 | 53 | 43 | 53 | 439 |

Монгол Улсын сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номыг ашиглаж байгаагүй гэж хариулсан 32 хувь буюу 58 оролцогчийг 100 хувь гэж үзэн шалтгааныг тодруулбал, 56.9 хувь нь олоход хүндрэл үүсдэг /номын дэлгүүр, номын санд байдаггүй/, 26.2 хувь нь энэ номын талаар сонсож байгаагүй, 9.2 хувь нь сайн ном гэж хэн нэгэн зөвлөж байгаагүй гэж хариулсан нь ихэнх хувийг эзэлж байна.

График 4. Монгол Улсын сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номыг яагаад ашиглаж байгаагүй вэ? /Нийт 65 оролцогч хариулсан/



Тус ботийг хэр ашиглаж байгааг нарийвчлан харвал 72 хувь буюу 147 оролцогч шаардлагатай үед үргэлж ашигладаг гэсэн бол 28 хувь буюу 58 оролцогч ашиглахыг хүсэвч олддоггүй, ашиглах шаардлага гардаггүй гэсэн байна.

Тус хариултуудыг судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтээр харьцуулалт хийв. Үүнд:


- Шаардлагатай үед үргэлж ашигладаг гэж хариулсан 147 оролцогчдыг 100 хувь гэж үзэн оролцогчдыг хөдөлмөр эрхлэлтээр нь харьцуулан харвал бусдаасаа хамгийн их ашигладаг нь бусад хуульчид 27.9 хувь (41)-аар, шүүгчид 26.5 хувь (39)-аар, оюутнууд 15% (22)-аар ашиглаж байна.
- Ашиглахыг хүсэвч олддоггүй гэж бусад хуульч болон төрийн албан хаагч болон бусад оролцогчдын тус бүр 1 оролцогч хариулсан байна.
- Ашиглах шаардлага гардаггүй гэж хариулсан байдлыг харахад бусад шүүгч 25% (14), шүүгч 21.4 хувь (12) байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Тус ботийг хэр ашигладаг болохыг хариулав

| Судалгаанд оролцогчид /хөдөлмөр эрхлэлт/ | Тус ботийг хэр ашигладаг вэ? | | | | | | Нийт |
|--|-----------------------------------|------|----------------------------|------|-----------------------------|-------|------|
| | Шаардлагатай үед үргэлж ашигладаг | | Ашиглахыг хүсэвч олддоггүй | | Ашиглах шаардлага гардаггүй | | |
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | |
| Архивч | 1 | 0.7% | - | - | 4 | 7.1% | 5 |
| Багш, судлаач | 12 | 8.2% | - | - | 7 | 12.5% | 19 |
| Оюутан | 22 | 15% | - | - | 2 | 3.6% | 24 |
| Өмгөөлөгч | 11 | 7.5% | - | - | 4 | 7.1% | 15 |


| | | | | | | | |
|--------------------------------------|------------|-------------|----------|-------------|-----------|-------------|------------|
| Прокурор | 3 | 2% | - | - | - | - | 3 |
| Шүүгч | 39 | 26.5% | - | - | 12 | 21.4% | 51 |
| Шүүгчийн туслах | 7 | 4.8% | - | - | 3 | 5.4% | 10 |
| Шүүхийн захиргааны ажилтан | 4 | 2.7% | - | - | 3 | 5.4% | 7 |
| Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга | 2 | 1.4% | - | - | 6 | 10.7% | 8 |
| Бусад хуульч | 41 | 27.9% | 1 | 50% | 14 | 25% | 56 |
| Шүүхийн тамгын газрын дарга | 2 | 1.4% | - | - | - | - | 2 |
| Төрийн албан хаагч болон бусад | 3 | 2% | 1 | 50% | 1 | 1.8% | 5 |
| Нийт | 147 | 100% | 2 | 100% | 56 | 100% | 205 |

График 5. Боть номыг хэр ашигладаг болохыг ерөнхийд нь харуулав




Тус номыг ашигладаг нийт 147 хэрэглэгчдийн хувьд боть ном дахь шийдвэрүүдээс иргэний хэрэгтэй холбоотой хэргийн шийдвэр 49.7 хувьд нь, эрүүгийн хэрэгтэй холбоотой хэргийн шийдвэр 33.3 хувьд нь харин үлдсэн 19 хувьд нь захиргааны хэрэгтэй холбоотой шийдвэрүүд хамгийн их хэрэгтэй болдог гэж хариулсан байна.

График 6. Ботиос аль шүүхийн шийдвэрээр шийдвэрлэгдсэн хэргүүд илүү хэрэг болдог вэ?



Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлд хэвлэгдэж буй шийдвэрийн чанарыг 147 оролцогчдоор үнэлүүлсэн үнэлгээний хувьд сайн, маш сайн гэж 70.1 хувь нь, дунд зэрэг гэж 22.4 хувь нь үнэлсэн бол үлдсэн 7.5 хувь нь муу, маш муу гэж хариулсан байна.

График 7. Таны бодлоор шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлд хэвлэгдэж буй шийдвэрийн чанарыг үнэлнэ үү.



Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл зорилтдоо хүрч чадаж буй эсэхийг үнэлүүлэхэд **58 хувь нь маш сайн, сайн**, 33 хувь нь дунд зэрэг гэсэн бол 8 хувь нь муу, маш муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Тодруулбал;

- Шүүхийн шийдвэрийн чанарыг дээшлүүлэхэд нөлөөлж буй байдлын үнэлгээний хувьд **маш сайн, сайн 59.5 хувь**, дунд зэрэг 32.2 хувь, муу маш муу 8.3 хувь гэж үнэлсэн байна;
- Шүүхийн шийдвэрийг эргэлтэд оруулах, олон нийтэд шүүхийн үйлчилгээг нээлттэй, ил тод хүргэхэд нөлөөлж буй байдлын үнэлгээний хувьд **маш сайн, сайн 57.1 хувь**, дунд зэрэг 34.1 хувь, муу маш муу 8.8 хувь гэж үнэлжээ;
- Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг өргөжүүлэх, судалгаа шинжилгээний ач холбогдлыг ойлгуулахад нөлөөлж буй байдлын үнэлгээний тухайд **58.5 хувь нь маш сайн, сайн**, 33.7 хувь нь дунд зэрэг гэсэн бол 7.8 хувь нь муу, маш муу гэсэн үнэлгээг өгсөн байна.

Хүснэгт 4. Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл нь дараах зорилтод хүрч чадаж буй эсэхийг үнэлнэ үү.

| | Маш сайн | | Сайн | | Дунд зэрэг | | Муу | | Маш муу | |
|---|----------|------|------|------|------------|------|-----|------|---------|------|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Шүүхийн шийдвэрийн чанарыг дээшлүүлэхэд нөлөөлж буй байдлын үнэлгээ | 35 | 17.1 | 87 | 42.4 | 66 | 32.2 | 9 | 4.4 | 8 | 3.9 |
| Шүүхийн шийдвэрийг эргэлтэд оруулах, олон нийтэд шүүхийн үйлчилгээг нээлттэй, ил тод хүргэхэд нөлөөлж буй байдлын үнэлгээ | 33 | 16.1 | 84 | 41 | 70 | 34.1 | 18 | 8.8 | - | - |
| Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг өргөжүүлэх, | 36 | 17.6 | 84 | 41 | 69 | 33.7 | 9 | 4.4 | 7 | 3.4 |

| судалгаа шинжилгээний ач ойлгуулахад нөлөөлж буй байдлын үнэлгээ | | | | | | | | | | |
|--|-----|------|-----|------|-----|------|----|-----|----|-----|
| Нийт | 104 | 16.9 | 255 | 41.4 | 205 | 33.3 | 36 | 5.8 | 15 | 2.4 |

Нийт судалгаанд оролцогчдын 75.1 хувь нь шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл ботийг үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Шаардлагатай эсэх асуулгыг судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтээр харьцуулан, тийм гэсэн хариултыг 100 хувь гэж үзвэл бусад хуульчид, шүүгчид болон оюутнуудын хувь бусдаасаа хамгийн өндөр хувьтай байгаа нь эдгээр субъектүүд өндөр хүлээлттэй байгааг илэрхийлж байна.

График 8. Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл ботийг үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай юу? гэсэн асуулгыг субъект тус бүрээр харьцуулан харуулав



График 9-өөр субъект тус бүрийн хувьд сонгомол шийдвэрийн эмхэтгэл ботийг үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай эсэхийг хэрхэн үзэж байгааг тооцоолбол төрийн албан хаагч болон бусад, шүүхийн захиргааны ажилтан, прокурор болон архивчдын хувьд бүгд буюу 100 хувь үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж хариулсан.

Харин шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын 87.5 хувь, оюутнуудын 87.5 хувь, өмгөөлөгч нарын 80 хувь нь үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж үзсэн нь хамгийн их хувийг эзэлж байна.

График 9. Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл ботийг үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай юу? гэсэн асуулгыг субъект тус бүрийг 100% гэж үзэн субъект тус бүрийн хувьд харьцуулан харуулав



Судалгаанд оролцсон 205 оролцогчдоос 101 оролцогчид шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номын ач холбогдлын талаар санал бодлоо хуваалцсан байна.

Тус санал бодлыг нэгтгэн дүгнэвэл багш, судлаач нарын хувьд эрдэм шинжилгээ, судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж чаддаг төдийгүй эрх зүйн ангийн оюутнуудад практикийн чухал ач холбогдолтой ном гэсэн байна.

Харин шинэ хуульч, эрх зүйч нарын хувьд тэдний ширээний ном болж өөрт тулгарсан шүүхийн шийдвэрийг харьцуулан судлах, хуулийн хүрээн дэх эргэлзээтэй асуудлын учрыг тайлахад тус болж хуулийг нэг мөр ойлгож, адил тэгш байдлыг тогтооход эерэг нөлөөтэй гэв.

Шигтгээ 1. Судалгаанд оролцогчид шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлийн ач холбогдлыг дараах байдлаар харж байна.

...Эрдэм шинжилгээ судалгаа хийхэд болон шүүхийн шийдвэр боловсруулах, шүүхүүд нэг практик, адил тэгш байдлыг тогтооход шаардлагатай.

... Олон хуульчдын гарын авлага болж чаддаг байгаа. Мөн жишиг шүүхийн шийдвэрийг харах боломжтой. Мэдлэгийг өгч чадаж байна. Улам их шийдвэрийг оруулж, олон нийтийн хүртээл болгох талд дээр илүү анхаарах нь чухал юм..


...Судлаач болон шинэ шүүгч, хуульч, эрх зүйч нарт хөтөч болохоос гадна оюутан залуус судалгааны томоохон гарын авлага болдог.

...Онолоос илүү практикт тулгардаг асуудлыг шийдвэрлэх жишээ байдаг учраас заавал шаардлагатай гэж үзэж байна. Мөн хэвлэмэл байх нь ашиглахад илүү хялбар.

Эх сурвалж: Судалгааны нээлттэй асуулгын үр дүн

Тус номын “Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл” гэсэн одоогийн нэрийг өөрчлөх эсэх асуулгад 88 хувь нь үгүй, өөрчлөх шаардлагагүй гэж хариулсан байна.

График 10. “Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл” гэсэн одоогийн нэрийг өөрчлөх шаардлагатай эсэхийг харуулав



Тус номын “Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл” гэсэн одоогийн нэрийг өөрчлөх шаардлагатай гэж хариулсан 6 хувь буюу 13 оролцогчид өөрт байгаа хувилбар нэрийг санал болгож, ямар учраас солих шаардлагатай байгаа үндэслэлийг нь нэгтгэн хүснэгт 5-аар харуулав.

Хүснэгт 5.

| № | Оролцогчдын санал |
|----|--|
| 1 | Сонгомол гэсэн шалгуураар шийдвэрийг сонгодоггүй учраас сонгомол гэдэг нь тохиромжгүй. |
| 2 | Сонгомол гэдэг үг хасах. |
| 3 | "Сонгомол" гэх үг зохимжгүй санагддаг. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цуврал эмхэтгэл гэж нэрлэх. |
| 4 | Сонгомол гэх үг шаардлагагүй. Шүүхийн шийдвэр тухайн хэргийн кейс бүрд сонгомол учраас. |
| 5 | Сонгомол гэх үгийг хасах хэрэгтэй. |
| 6 | Шүүхийн шийдвэрийн түүвэр эмхэтгэл |
| 7 | Сэдвээр нь ангилж түүвэр гэж нэрлэвэл зүгээр |
| 8 | Монгол Улсын зарим шүүхийн шийдвэрүүдийн эмхэтгэл |
| 9 | Шүүхийн бүхий л шийдвэр ач холбогдол агуулдаг. Иймд шийдвэрийг ангилах нь зохимжгүй |
| 10 | Илүү сайн шийдвэрүүд орхигдуулсан байдаг тул нэрийг эргэж харах нь зөв. |
| 11 | Ботийг хэвлэмэл байдлаар гаргахгүйгээр шийдвэрийг цахим санд тусдаа төрөл болгон оруулах. |
| 12 | Шудрангүй, соён гэгээрэхүйн дэнс |


| | |
|----|-------------------------------|
| 13 | Шилэгдмэл шийдвэрийн эмхэтгэл |
| 14 | Жишиг оршихуйн хэц |
| 15 | Шүүгчийн манлайллын тэмдэглэл |

3. ДҮГНЭЛТ

"Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл" боть номын хэрэглэгчдийн дунд хийсэн хэрэглээний судалгаанд 205 оролцогч оролцож, нэгдсэн дүнг боловсруулж, цаашид тус ботийг хэвлэх эсэх асуудалд дараах байдлаар үр дүн гарсан.

- Судалгаанд хамрагдсан оролцогчдын боловсролын түвшинг харвал 50 хувь нь бакалавр, 43% нь магистр, 4 хувь нь бүрэн дунд байсан бол үлдсэн 3 хувь нь докторын зэрэгтэй бөгөөд 54 хувь нь эрх зүйч мэргэжилтэй байна. Харин хүйсийн хувьд 65 хувь нь эмэгтэй, 35 хувь нь эрэгтэй байсан бол насны хувьд 33-37 нас, 38-аас дээш насныхан нийт судалгаанд оролцогчдын 67 хувийг эзэлсэн байна.
- Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн хувьд бусад хуульч 25.9 хувийг (n=53), шүүгч 24.9 хувийг (n=51) эзэлсэн нь хамгийн өндөр хувьтай байна.
- Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлд хэвлэгдэж буй шийдвэрийн чанарыг 147 оролцогчдоор үнэлүүлсэн үнэлгээний хувьд сайн, маш сайн гэж 70.1 хувь нь, дунд зэрэг гэж 22.4 хувь нь үнэлсэн бол үлдсэн 7.5 хувь нь муу, маш муу гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл зорилтдоо хүрч чадаж буй эсэхийг үнэлүүлэхэд **58 хувь нь маш сайн, сайн**, 33 хувь нь дунд зэрэг гэсэн бол 8 хувь нь муу, маш муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Тодруулбал;
- Нийт судалгаанд оролцогчдын **75.1 хувь нь** шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл ботийг үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж үзсэн байна. Тодруулбал;
 - ✓ Субъект тус бүрийн хувьд хэрхэн үзэж байгааг тооцоолбол төрийн албан хаагч болон бусад, шүүхийн захиргааны ажилтан, прокурор болон архивчдын хувьд бүгд буюу 100 хувь үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж хариулсан.
 - ✓ Мөн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын 87.5 хувь, оюутнуудын 87.5 хувь, өмгөөлөгч нарын 80 хувь нь үргэлжлүүлэн хэвлэх шаардлагатай гэж үзсэн нь хамгийн их хувийг эзэлж байна.
- Судалгаанд оролцсон 205 оролцогчдоос 101 оролцогчид шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл боть номын ач холбогдлын талаар санал бодлоо хуваалцсан байна. Тус санал бодлыг нэгтгэн дүгнэвэл сонгомол шийдвэрийн эмхэтгэл нь шүүхийн нээлттэй ил тод байдал, хууль хэрэглээний нэгдмэл чанарыг хангах, судалгааны эргэлтэд орж үндэсний эрх зүйг хөгжүүлэх зорилтдоо хүрч байгааг харуулсан тул тус номыг хэвлэх нь зайлшгүй шаардлагатай.
- Тус номын "Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл" гэсэн одоогийн нэрийг өөрчлөх эсэх асуулгад 88 хувь нь үгүй, өөрчлөх шаардлагагүй гэж хариулсан байна.
- Тийм өөрчлөх шаардлагатай гэж үзсэн 15 оролцогчийн саналаас 5 оролцогч сонгомол гэдэг үгийг хасах хэрэгтэй гэсэн.

4. ХАВСРАЛТ



МУХАУТ-ын зөвхөн гшүүн
"МӨНХИЙН ҮСЭГ" ХХК
УБД: 9011256123
210628 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
Ажлын гудамж-135, Шуудангийн хайрцат-28/41
Утас: 70134544, 70140459, факс: 976-70141316
E-mail: info@munkhin-useg.mn

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

2022.05.31 1-3/


-ны № _____ -т

Үнийн санал хүргүүлэх тухай

| Бүтээгдэхүүний нэр | Хэвлэх хэмжээ | Хэвлэх өнгө | Хэвлэх материал | Хэвлэх тоо | Нэгж үнэ /төг/ |
|---|---------------|-------------------------|--|------------|----------------|
| МУ-ын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл VII боть | A4 /520 нүүр/ | Дотор 1+1 Хавтас 4+0 | Дотор 80 гр гөлгөр шаргал цаас, Хавтас хатуу картонон хавтастай, нэр шар фольга дарах. Нурууг оёж наах | 300 | 41.000 |


Эх баталснаас хойш ажлын 14 хоногт хэвлэн нийлүүлнэ. Энэхүү үнийн санал нь 30 хоногийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Бүтээгдэхүүний нөхцөл, үзүүлэлт өөрчлөгдсөн тохиолдолд үнийн саналд өөрчлөлт орохыг анхаарна уу.

Бидний саналыг хүлээн авч, хамтран ажиллана гэдэгт
итгэж байна.

Үнийн санал боловсруулсан:  Маркетингийн менежер *О.Ганчимэг*
Утас: 99084096, 88886505

www.munkhin-useg.mn

 www.facebook.com/MunkhinUsegLLC

 www.twitter.com/MunkhinUsegLLC